

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
САНГИЙН САЙДАД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААР ТӨСВИЙН
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 09 дүгээр
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Л. Эрдэнэчимэг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг 2015 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Улсын Их Хурлын гишүүн Баярбаатарын Болорыг Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар томилуулахаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороо 2015 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлт гаргасныг Та бүхэнд танилцуулж байна.

Баярбаатар овогтой Болор нь 1985-1995 онд ерөнхий боловсролын дунд сургууль, 1995-1997 онд Бельгийн Вант Улсын Европын их сургууль, 2012 онд Шинжлэх ухаан, технологийн их сургуульд тус тус суралцаж төгссөн.

1997-2000 онд төрийн өмчит "НИК" компанийн гадаад харилцааны мэргэжилтэн, 2000-2006 онд "Гарьд Тур" ХХК-ийн ерөнхий захирал, 2006-2008 онд "Тиара Монголиа" төслийн удирдагч, 2008-2012 онд Гадаад харилцааны дэд сайдаар ажиллаж байсан бөгөөд 2012 оноос Улсын Их Хурлын гишүүн, 2014 оноос Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны даргаар тус тус ажиллаж байна.

Б.Болорыг Засгийн газраас дэвшүүлж байгаа зорилтуудыг биелүүлэх, танхимын зарчмаар ажиллах, удирдан зохион байгуулах чадвартай, ажил хэрэгч чанартай гэж үзэж, Засгийн газрын гишүүн, Сангийн сайдын албан тушаалд нэр дэвшүүлсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Улаан төсвийн орлого их хэмжээгээр тасарч, төсөв хүндрэлтэй байгаа үед төсвийн зарлагад анхаарч, санхүүжилтийг зөв зохистой хэрэгжүүлж, Сангийн яамны төрийн мэргэшсэн албан хаагчдыг түшиж, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах хэрэгтэй гэсэн санал хэлэв.


Улсын Их Хурлын гишүүн Б.Болорыг Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар томилуулах саналыг Төсвийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Баярбаатарын Болорыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар томилуулах талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.БОЛОР